



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/039/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Намжил

Утас: 70453799, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

### 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

### 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
  - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
  - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
  - 3.5.3 Нэмэлт төсөв

### 4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
  - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
  - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
  - 4.5.1 Завсрын аудитын талаар
  - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж  
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,  
Утас/факс: 7045-3317,  
Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2026.01.26 № УВА-2026/039/МА-СТА-ТЧЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА  
Л.ЧИНБАТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050017

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,802,305,945.58</u></b>	<b><u>1,673,466,691.98</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,802,305,945.58	1,673,466,691.98
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,091,418,617.58	1,557,892,087.98
35110	Тусгай зориулалттай материал	1,090,668,617.58	1,557,142,087.98
35130	Эм боох материал	750,000.00	750,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	696,017,328.00	100,914,604.00
35410	Бичиг хэргийн материал	325,080.00	711,220.00
35420	Аж ахуйн материал	532,042,906.00	6,342,844.00
35430	Сэлбэг хэрэгсэл	63,870,203.00	54,956,600.00
35440	Түлш, шатах тослох материал	59,500,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	40,279,139.00	38,903,940.00
35600	Мал амьтад	14,870,000.00	14,660,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,760,169,856.88</u></b>	<b><u>5,621,806,053.99</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,760,169,856.88	5,621,806,053.99
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,781,541,656.88	4,643,177,853.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,845,556,151.00	3,868,556,151.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-788,567,113.00	-871,540,354.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,759,436,213.33	6,123,186,213.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-4,876,947,615.03
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	528,661,836.51	627,701,836.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-180,159,841.11	-247,071,558.74
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,693,706.64	29,693,706.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,523,775.13	-10,400,525.24
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	978,628,200.00	978,628,200.00
39301	Програм хангамж	1,200,000.00	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,200,000.00	-1,200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	978,628,200.00	978,628,200.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>7,562,475,802.46</u></b>	<b><u>7,295,272,745.97</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>7,562,475,802.46</u></b>	<b><u>7,295,272,745.97</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	7,562,475,802.46	7,295,272,745.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,543,338,689.60	1,543,338,689.60
51101	Өмч: - төрийн	1,543,338,689.60	1,543,338,689.60
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	5,475,371,376.70	5,208,168,320.21
51210	Өмнөх үеийн үр дүн	5,475,371,376.70	5,475,371,376.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-267,203,056.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	543,765,736.16	543,765,736.16

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,562,475,802.46	7,295,272,745.97
---	--	------------------	------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,070,466,776.30	6,970,038,554.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,416,747,976.30	1,612,445,210.90
120	Нийтлэг татварын бус орлого	1,416,747,976.30	1,612,445,210.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,416,747,976.30	1,612,445,210.90
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,416,747,976.30	1,612,445,210.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,653,718,800.00	5,357,593,344.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	274,533,500.00	200,657,844.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нээц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	140,067,000.00	174,955,344.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,361,500.00	25,492,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000.00	210,000.00
1330	Төсвийн захирагчдаас	4,379,185,300.00	5,156,935,500.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,379,185,300.00	5,156,935,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,537,681,298.65	7,153,241,611.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,537,681,298.65	7,153,241,611.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,499,467,708.88	7,122,866,815.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,577,634,523.00	4,210,513,945.00
210101	Үндсэн цалин	2,072,560,766.00	2,585,310,045.00
210102	Нэмэгдэл	1,329,532,557.00	1,434,245,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,064,000.00	50,311,800.00
210104	Урамшуулал	122,477,200.00	140,647,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,523,798.00	112,510,674.00
210201	Тэтгэврийн даатгал	10,418,100.00	6,506,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,225,700.00	1,324,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	613,400.00	687,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	613,400.00	6,044,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	81,653,198.00	97,948,974.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	286,228,505.23	317,386,592.71
210301	Гэрэл, цахилгаан	23,020,924.95	41,045,830.55
210302	Түлш, халаалт	260,242,809.28	273,131,386.16
210303	Цэвэр, бохир ус	2,964,771.00	3,209,376.00
2104	Хангамж, бараа материалын зардал	171,411,958.00	283,938,348.91
210401	Бичиг хэрэг	8,439,730.00	5,166,260.00
210402	Тээвэр, шатахуун	157,777,928.00	254,237,544.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,532,700.00	4,321,899.91
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,661,600.00	20,212,645.00

2105	Нормативт зардал	194,604,867.25	869,051,002.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,180,300.00	1,986,700.00
210502	Хоол, хүнс	122,108,600.00	185,935,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	71,315,967.25	681,129,302.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	320,912,800.00	343,863,590.66
210604	Урсгал засвар	316,290,600.00	343,863,590.66
2107	Томилолт, зочны зардал	50,261,000.00	15,952,500.00
210702	Дотоод албан томилолт	50,261,000.00	15,952,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,201,534.00	45,373,604.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,181,000.00	16,889,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,536,125.00	1,686,004.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	453,000.00	726,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,009,100.00	732,300.00
210807	Газрын төлбөр	3,215,909.00	24,533,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	787,688,723.40	924,276,558.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,278,725.34	100,380,288.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,833,500.00	18,950,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	711,576,498.06	804,945,469.54
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,213,589.77	30,374,795.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,239,800.00	6,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,239,800.00	6,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,973,789.77	24,374,795.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,973,789.77	24,374,795.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>532,785,477.65</u>	<u>-183,203,056.49</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	84,000,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	84,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-84,000,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>532,785,477.65</u>	<u>-267,203,056.49</u>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>4,653,718,800.00</b>	<b>5,357,593,344.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,653,718,800.00</b>	<b>5,357,593,344.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	274,533,500.00	200,657,844.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	140,067,000.00	174,955,344.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,361,500.00	25,492,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000.00	210,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>4,379,185,300.00</b>	<b>5,156,935,500.00</b>
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,379,185,300.00	5,156,935,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>4,653,718,800.00</b>	<b>5,357,593,344.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,653,718,800.00</b>	<b>5,357,593,344.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,584,835,210.23</b>	<b>5,274,052,848.03</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,577,634,523.00</b>	<b>4,210,513,945.00</b>
210101	Үндсэн цалин	2,072,560,766.00	2,585,310,045.00
210102	Нэмэгдэл	1,329,532,557.00	1,434,245,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,064,000.00	50,311,800.00
210104	Урамшуулал	122,477,200.00	140,647,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>94,523,798.00</b>	<b>112,510,674.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	10,418,100.00	6,506,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,225,700.00	1,324,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	613,400.00	687,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	613,400.00	6,044,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	81,653,198.00	97,948,974.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>286,228,505.23</b>	<b>317,386,592.71</b>
210301	Гэрэл, цахилгаан	23,020,924.95	41,045,830.55
210302	Түлш, халаалт	260,242,809.28	273,131,386.16
210303	Цэвэр, бохир ус	2,964,771.00	3,209,376.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>36,624,700.00</b>	<b>22,476,943.91</b>
210401	Бичиг хэрэг	3,655,400.00	172,000.00
210402	Тээвэр, шатахуун	27,775,000.00	11,667,544.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,532,700.00	4,321,899.91
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,661,600.00	6,315,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>119,808,900.00</b>	<b>181,882,700.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,180,300.00	1,986,700.00
210502	Хоол, хүнс	118,628,600.00	179,896,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>334,712,250.00</b>	<b>302,292,388.41</b>
210601	Багаж техник, хэрэгсэл	30,702,500.00	00.00

210604	Урсгал засвар	304,009,750.00	302,292,388.41
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>50,261,000.00</b>	<b>15,952,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	50,261,000.00	15,952,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,201,534.00</b>	<b>45,373,604.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,518,873.00	16,889,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,245,052.00	1,686,004.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	453,000.00	726,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,009,100.00	732,300.00
210807	Газрын төлбөр	3,169,109.00	24,533,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>68,840,000.00</b>	<b>65,663,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,000,000.00	42,987,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,840,000.00	22,675,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>68,883,589.77</b>	<b>83,540,495.97</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,909,800.00</b>	<b>12,115,700.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	4,736,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,909,800.00	7,379,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>51,973,789.77</b>	<b>71,424,795.97</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,973,789.77	24,374,795.97
223001	Бусад хөрөнгө	30,000,000.00	47,050,000.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,543,338,689.60	502,287,564.07	1,058,148,636.34	3,103,774,890.01

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,543,338,689.60	502,287,564.07	1,058,148,636.34	3,103,774,890.01	
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн		00.00	00.00	-178,130,277.46	-178,130,277.46
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,543,338,689.60</b>	<b>543,765,736.16</b>	<b>5,475,371,376.70</b>	<b>7,562,475,802.46</b>	
D01	<b>2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>1,543,338,689.60</b>	<b>543,765,736.16</b>	<b>5,475,371,376.70</b>	<b>7,562,475,802.46</b>	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,543,338,689.60	543,765,736.16	5,475,371,376.70	7,562,475,802.46	
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		00.00	00.00	00.00	00.00

D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-267,203,056.49	-267,203,056.49
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,543,338,689.60</b>	<b>543,765,736.16</b>	<b>5,208,168,320.21</b>	<b>7,295,272,745.97</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	0.00
	ХӨТӨЛБӨР 70708	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 80101	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,134,819,700.00	5,112,732,304.03	22,087,395.97
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	5,134,819,700.00	5,112,732,304.03	22,087,395.97
210	Бараа, үйлчилгээний зардал	5,134,819,700.00	5,112,732,304.03	22,087,395.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,213,192,900.00	4,210,513,945.00	2,678,955.00
210101	Үндсэн цалин	2,587,989,000.00	2,585,310,045.00	2,678,955.00
210102	Нэмэгдэл	1,434,245,100.00	1,434,245,100.00	-
210103	Унаа, болон бусад нехөн олговор	50,311,800.00	50,311,800.00	-
210104	Урамшуулал	140,647,000.00	140,647,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,334,900.00	112,510,674.00	2,824,226.00
210201	Тэтгэврийн даатгал	6,506,300.00	6,506,300.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	1,324,000.00	1,324,000.00	-
210203	ҮОМШӨ ний даатгал	687,300.00	687,300.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	6,044,100.00	6,044,100.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	100,773,200.00	97,948,974.00	2,824,226.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	318,276,100.00	317,386,592.71	889,507.29
210301	Гэрэл цахилгаан	40,123,100.00	41,045,830.55	(922,730.55)
210302	Түлш, халаалт	273,255,000.00	273,131,386.16	123,613.84
210303	Цэвэр, бохир ус	4,898,000.00	3,209,376.00	1,688,624.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,579,300.00	7,809,399.91	1,769,900.09

210401	Бичиг хэрэг	1,941,900.00	172,000.00	1,769,900.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,321,900.00	4,321,899.91	0.09
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	3,315,500.00	3,315,500.00	-
2105	Нормативд зардал	161,520,700.00	161,520,700.00	-
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,986,700.00	1,986,700.00	-
210502	Хоол, хүнс	159,534,000.00	159,534,000.00	-
2106	Эд хогшил худалдан авах	272,350,000.00	272,292,388.41	57,611.59
210604	Урсгал засвар	272,350,000.00	272,292,388.41	57,611.59
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	31,284,400.00	29,373,604.00	1,910,796.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,000.00	889,400.00	110,600.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,532,200.00	806,400.00	725,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,307,400.00	1,686,004.00	621,396.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,179,000.00	726,000.00	453,000.00
210806	Мэдээллийн технологийн зардал	732,300.00	732,300.00	-
210807	Газрын төлбөр	24,533,500.00	24,533,500.00	-
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	13,281,400.00	1,325,000.00	11,956,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,308,000.00	960,000.00	8,348,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,973,400.00	365,000.00	3,608,400.00
	ХӨТӨЛБӨР 70708		-	-
	АРГА ХЭМЖЭЭ 80714		-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,736,700.00	4,736,700.00	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	4,736,700.00	4,736,700.00	-
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,736,700.00	4,736,700.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,736,700.00	4,736,700.00	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,736,700.00	4,736,700.00	-
	ХӨТӨЛБӨР 70708		-	-
	АРГА ХЭМЖЭЭ 80802		-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,379,100.00	1,379,000.00	100.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,379,100.00	1,379,000.00	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,379,100.00	1,379,000.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,379,100.00	1,379,000.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,379,100.00	1,379,000.00	100.00
	ХӨТӨЛБӨР 70708		-	-
	АРГА ХЭМЖЭЭ 82310		-	-

2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,000,000.00	16,000,000.00	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	16,000,000.00	16,000,000.00	-
210	Бараа, үйлчилгээний зардал	16,000,000.00	16,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	16,000,000.00	16,000,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	16,000,000.00	16,000,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,156,935,500.00	5,156,935,500.00	
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,156,935,500.00	5,156,935,500.00	
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	5,156,935,500.00	5,156,935,500.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	0.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
	ХӨТӨЛБӨР 70708	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 80101	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	192,370,544.00	192,370,544.00	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	145,320,544.00	145,320,544.00	-
210	Бараа, үйлчилгээний зардал	-	145,320,544.00	145,320,544.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	14,667,544.00	14,667,544.00	-
210402	Тээвэр (шатахуун)	-	11,667,544.00	11,667,544.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	-	3,000,000.00	3,000,000.00	-
2105	Нормативт зардал	-	20,362,000.00	20,362,000.00	-
210502	Хоол, хүнс	-	20,362,000.00	20,362,000.00	-
2106	Эд хогшил худалдан авах	-	30,000,000.00	30,000,000.00	-
210604	Урсгал засвар	-	30,000,000.00	30,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	-	15,952,500.00	15,952,500.00	-
210702	Дотоод албан томилолт	-	15,952,500.00	15,952,500.00	-
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	-	64,338,500.00	64,338,500.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	42,027,700.00	42,027,700.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	22,310,800.00	22,310,800.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	47,050,000.00	47,050,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	47,050,000.00	47,050,000.00	-
223001	Бусад хөрөнгө	-	47,050,000.00	47,050,000.00	-

	ХӨТӨЛБӨР 70708	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 80802	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	6,000,000.00	6,000,000.00	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	6,000,000.00	6,000,000.00	-
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	6,000,000.00	6,000,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	6,000,000.00	6,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	6,000,000.00	6,000,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	200,657,844.00	200,657,844.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	200,657,844.00	200,657,844.00	-
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	174,955,344.00	174,955,344.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	25,492,500.00	25,492,500.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	210,000.00	210,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Онцгой байдлын газар нь гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшиг, осол, гал түймрийн эрсдэлийг бууруулах, авран хамгаалах гэсэн зорилгын дор үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

#### ***Увс аймгийн Онцгой байдлын газраас 2025 онд дэвшүүлсэн зорилт:***

1. Онцгой байдлын байгууллагын мэдээллийн санг бүрдүүлэх, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.
2. Алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах.
3. Алба хаагчдын ёс зүй сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх.

#### ***Увс аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний стратеги зорилт:***

Зорилт-1: Гамшгийн эрсдэлийн мэдээлэлд суурилсан удирдлага үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэл хуваалцах тогтолцоо, гамшгийн эрсдэлийн мэдээллийн санг хөгжүүлж, олон нийтэд нээлттэй болгоно.

Зорилт-2: Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх сургалт, судалгаа сурталчилгаа мэдээллийг эрчимжүүлж, хөрөнгө оруулалтыг бодитойгоор нэмэгдүүлэн, олон нийтийн оролцоог хангана.

Зорилт-3: Гамшгийн үеийн холбоо зарлан мэдээллийн тогтолцоонд дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлж, шинэ шатанд гаргаж, бэлтгэл бэлэн байдлыг хангана.

Зорилт-4: Гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх аврах нэгжийн үйлчлэх хүрээг нэмэгдүүлж, техник, тоног төхөөрөмжийг, стандартын түвшинд хүргэж, хангалтыг нэмэгдүүлнэ.

Зорилт-5: Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг стандарт хяналтад тулгуурлан хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлж, гамшиг, аюулт үзэгдлийн сөрөг нөлөөлөл хохирол, техник технологийн горимын зөрчлийг бууруулна.

Зорилт-6: Гамшгийн шуурхай удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах чадавхыг нэмэгдүүлнэ.

Зорилт-7: Галын аюулгүй байдлыг хангаж, гал түймэр унтраах, аврах чадавхыг бэхжүүлж, хүч хэрэгслийн хангалт, бэлэн байдлыг сайжруулна.

Зорилт-8: Нөөцийн бараа материалыг гамшиг тохиолдсон үед 100000 хүнийг анхдагч хэрэгцээгээр хангахаар бэлтгэн, бэлэн байдлыг хангаж, стратегийн зориулалттай нөөцийн хадгалалт, хамгаалалтад дэвшилтэт технологи, хиймэл оюун ухааныг ашиглаж эхэлнэ.

Зорилт-9: Удирдлагын манлайлал, хүний нөөцийн хөгжлийг хангаж, алба хаагчдыг чадавхжуулах, аюулгүй байдал, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн баталгааг сайжруулна.

Зорилт-10: Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

Зорилт-11: Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд мэдээллийн технологи, инновацыг нэвтрүүлж, цахим мэдээллийн системийг хөгжүүлнэ.

Зорилт-12: Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ар тал хангалт үйлчилгээг сайжруулна.

Зорилт-13: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үр дүнг дээшлүүлнэ.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Онцгой байдлын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Гамшгаас хамгаалах тухай хууль
- Галын аюулгүй байдлын тухай хууль
- Улсын нөөцийн тухай болон
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Төрийн болон албаны нууцын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,

- Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Онцгой байдлын газар нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/293 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчим, бүртгэлийн суурийг тодорхойлсон журам зааврыг нэгтгэн боловсруулсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн дагуу санхүүгийн бүртгэл хөтлөн хэрэгжүүлэн ажиллаж байна

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 267,203.1 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	1,802,305.9	1,673,466.7	-128,839.2
Үндсэн хөрөнгө	5,760,169.9	5,621,806.0	-138,363.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,562,475.8</b>	<b>7,295,272.7</b>	<b>-267,203.1</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,562,475.8	7,295,272.7	-267,203.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>7,562,475.8</b>	<b>7,295,272.7</b>	<b>-267,203.1</b>

Мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, урьдчилж гарсан зардлын эхний болон эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 1,673,466.7 мянган төгрөг болж 128,839.2 мянган төгрөгөөр буурсан нь Онцгой байдлын ерөнхий газар болон бусад салбараас авсан хангалтын дүрэмт хувцас, хэрэгслийг бараа материалын данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 5,621,806.0 мянган төгрөг болж 138,363.9 мянган төгрөгөөр буурсан нь авто тээврийн хэрэгслийн дахин үнэлгээний хасагдуулга, салбар хооронд тээврийн хэрэгсэл шилжүүлсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,295,272.7 мянган төгрөг болж 267,203.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 899,571.8 мянган төгрөгөөр буюу 14.8 хувиар өссөн байна. Орлого өсөхөд үндсэн цалин нэмэгдсэн болон үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,615,560.3 мянган төгрөгөөр буюу 29.2 хувиар өссөн байна. Зарлага өсөхөд үндсэн цалин, бараа материалын зарлага нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,833,525.1 мянга, урсгал шилжүүлгээр 32,580.0 мянга, нийт зарлагыг 4,866,105.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 290,830.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 5,156,935.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70708 гамшгаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн 80101 үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,156,935.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,156,935.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,134,848.0 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 22,087.4 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллыг 0.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70708-Гамшгаас урьдчилан сэргийлэх 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	5,134,819.7	5,112,732.3	22,087.4	99.6
2	70708-Гамшгаас урьдчилан сэргийлэх 80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	4,736.7	4,736.7	0	100

3	70708-Гамшгаас урьдчилан сэргийлэх 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,379.1	1,379.0	0.1	99.9
4	70708-Гамшгаас урьдчилан сэргийлэх 80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	16,000.0	16,000.0	0	100
	Нийт	5,156,935.5	5,134,848.0	22,087.5	

Зарцуулагдаагүй үлдэгдэл 22,087.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	1,200.0	Acoluos, Payroll
2	Унаа, хоолны зардал	50,311.8	Ажилтнуудад хоолны хөнгөлөлт 8.0 мянга, унааны хөнгөлөлт 1.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар	8,285.0	Аймгийн ИТХ, ОБГ-ын даргын шийдвэрээр 5 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	14,390.8	Гадаад томилолтын зардал байхгүй бөгөөд аймгийн ИТХ, Засаг даргын зүгээс төсвийг шийдэж хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 2 албан хаагчийг 14,390.8 мянган төгрөгөөр гадаад улсад сургалтад хамруулсан байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	-	Орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл, мэдээлэл	16,000.0	Мэдээ, мэдээлэл, видео контент бэлтгэж нийтлүүлэх.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах аймаг орон нутгийн байгууллагын шийдвэрээр нийт 174,955.3 мянга, дээд шатны төсвийн захирагч буюу Онцгой байдлын ерөнхий газраас 25,492.5 мянга, бусад нэмэлт орлого буюу цахим тендерийн хураамж 210.0 мянга, нийт 200,657.8 мянган төгрөгийн орлого бүртгэсэн байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас тээвэр шатахууны зардалд 11,667.5 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлсийн зардалд 3,000.0 мянга, хоол хүнсний зардалд 20,362.0 мянга, урсгал засварын зардалд 30,000.0 мянга,

дотоод албан томилолтын зардалд 15,952.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 42,027.7 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 22,310.8 мянга, бусад хөрөнгийн зардалд 47,050.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 6,000.0 мянга, нийт 198,370.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулаагүй үлдэгдэл 2,287.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 41, 60 дугаар ангийн ээлжийн алба хаагчдын хоол хүнсний материал нийлүүлэгчийг шалгаруулах УВАОБГ/20250102001 дугаартай багц-1, багц-2 тендерт шалгарсан “Номин хөхий туруун” ХХК, Баруунтуруун сум дахь Гал түймэр унтраах, аврах 60 дугаар ангийн барилгын дотор хэсэгчилсэн засварын ажил гүйцэтгэгчийг шалгаруулах УАОБГ/20250101002 дугаартай тендерт шалгарсан “Арвижих-Увс” ХХК-тай гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Онцгой байдлын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 45/17 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,537,681.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 55,376.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 44,301.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 7,153,241.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 71,532.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 57,225.9 мянган төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Онцгой байдлын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Онцгой байдлын газар нь нууцын зэрэглэлтэй байгууллага тул батлагдсан төсөв, бүтэц, орон тоо гэх мэт зарим мэдээллийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд байршуулдаггүй байна. Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 169, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй бөгөөд зөвлөмж өгөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагүй аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Дүн													

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.НАМЖИЛ/

2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр